

НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСАГ,
ТҮҮХ, СОЁЛ

ЗҮҮН ХОЙТ АЗИЙН ЗАРИМ ОРНЫ
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН
АСУУДАЛ

Д. Баясгалан

Орчин үеийн шинжлэх ухаан техникийн эрчимтэй хөгжилтэй уялдан тээвэр холбооны салбар шинэ техник, технологиор шинэчлэгдэн улс хоорондын худалдааны хэмжээ нэмэгдэж, капиталын эргэлт тасралтгүй өргөжин хөгжиж байгаагаас олон улсын эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа улам өргөжих боллоо. Эдийн засгийн энэхүү нээлттэй ертөнцөд ямар ч улс орон цорын ганц өөрийн хүчээр бие даан хөгжих бололцоогүй болж байна. Түүхэн зайлшгүй энэ үйл явцаас шалтгаалан улс хоорондын харилцаа, хамтын ажиллагаа олон хэлбэрийг агуулж байгаагийн нэг нь бүс нутгийн хамтын ажиллагаа юм. Хамтын ажиллагааны энэ хэлбэр нь улс хоорондын харилцаанд харилцан ашигтай нөлөө үзүүлж байгаа төдийгүй дэлхийн эдийн засгийг богино хугацаанд интеграцчлахад тус дөхөм үзүүлэх билээ.

Сүүлийн жилүүдэд Ази, Номхон далайн бүс нутгийн эрчимтэй хөгжил нь дэлхийн олон нийтийн анхаарлыг ихэд татах боллоо. Энэ бүс нутаг хүн ам, байгалийн баялаг, зах зээлийн хүч нөөц, шинжлэх ухаан техникийн чадавхи зэрэг олон үзүүлэлтээрээ эдийн засгийн асар их бололцоо, нөөцийг агуулж байна.

70-аад оны сүүлчээс Ази, Номхон далайн бүс нутгийн худалдаа, эдийн засгийн хөгжил эрч хүчээ авчээ. 1985 онд Ази, Номхон далайн бүс нутгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь дэлхийн нийт бүтээг-

Д. Баясгалан. —Зүүн хойт Ази судлалын төвийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, түүхийн ухааны дэд эрдэмтэн.

дэхүүн үйлдвэрлэлийн 48,1 хувь, тэдгээр орны экспорт, импорт нь дэлхийн экспорт, импортын 54,1 хувь болжээ. Тус бүс нутгийн эдийн засгийн хөгжилд гол үүргийг худалдаа гүйцэтгэж байна. 80-аад оны сүүлч болоход Ази Номхон далайн худалдаа 70-аад онтой харьцуулахад 23 хувиар өсч, бүс нутгийн худалдаанд Япон, Тайвань, Өмнөд Солонгос гол байр суурийг эзлэх болов. Энэ бүхэн нь тус бүс нутагт шинээр аж үйлдвэржсэн орнууд буюу «Азийн барууд» бий болсонтой холбоотой юм. Хэвлэлийн мэдээнээс үзвэл 2000 он болоход Ази, Номхон далайн бүс нутгийн үйлдвэрлэлийн ерөнхий өсөлт дэлхийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 70 хувийг эзлэх юм.¹ Иймээс сүүлийн жилүүдэд Ази, Номхон далайн болон ялангуяа Зүүн хойт Азийн эрчимтэй хөгжлийн асуудлыг сонирхон авч үзэж, судлах явдал ихээхэн өргөжиж байна.

Ази, Номхон далайн бүс нутгийн хөгжилд Зүүн хойт Ази чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Энэ бүс нутагт нийгмийн хоёр байгуулал, хөгжиж байгаа, шинээр аж үйлдвэржсэн, хөгжингүй зэрэг хөгжлийн янз бүрийн төвшинтэй орнууд байна. Гэвч энэ бүхэн нь эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэхэд саад тотгор болоогүй, харин ч бүс нутгийн шинжтэй эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд зохих нөлөө үзүүлсэн юм. Зүүн хойт Азийн бүс нутагт өрнөсөн энэхүү шинэчлэгдсэн эдийн засгийн түүхэн шинжтэй үйл явдал нь аажмаар дэлхий нийтийн ач холбогдол бүхий үйл явц болж байна. Ингэснээрээ «орчин үеийн дэлхий дахины түүхэнд Зүүн хойт Ази бол улс түмний анхаарал татах» «онцгой цэгийн» нэг болж байна.

1960—70-аад он бол дэлхий дахинд аж үйлдвэрийн бүтэц эрс өөрчлөгдсөн үе юм. Аж үйлдвэр хөгжсөн хөгжингүй орнуудад шинжлэх ухаан, техникийн хувьсгал эрчимжиж, аж үйлдвэрийн хөгжил улам хурдассаныг Өмнөд Солонгос, Япон чадамгай ашигласнаар эдийн засгийн чадавхи нь өндөр хурдацтай хөгжиж Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засагт нөлөө бүхий хүчин болсон юм. Өмнөд Солонгос нь энэ хугацаанд аж үйлдвэр хөгжсөн АНУ, Япон зэрэг улсаас үйлдвэрлэлийн техник технологи авч, өөрийн ажиллах хүчинд тулгуурлан экспортын чиглэлтэй үйлдвэрийг өндөр хурдацтай хөгжүүлжээ. Хөгжлийн энэ арга нь одоо Ази, Номхон далайн бүс нутгийн аж үйлдвэр шинэ тутам хөгжсөн улс орнууд, Зүүн өмнөд Азийн нэлээд орнуудын хөгжилд биелэлээ олж байна.

1955—1975 оны хоорондох 20 жилд Японы хүн амд ноогдох үйлдвэрлэлийн дундач өсөлт 7,8 хувь болсноор бодит орлого нь есөн жил тутамд 1 дахин өсчээ. Өмнөд Солонгос 1965—1985 оны хооронд хүн амд ноогдох үйлдвэрлэлийн дундач өсөлтөөр 6,6 хувь болсон ба бодит орлого нь 11 жил тутамд 1 дахин өссөн байна.² 1978 он болоход Японы хүн амд ноогдох үйлдвэрлэлийн хэмжээ ерөнхийдөө АНУ-тай тэнцсэн байна.³ 1986 оноос АНУ-г гүйцэн түрүүлж эдийн засгийн үсрэнгүй хөгжилтэй улс болж, хүн амд ноогдох үйлдвэрлэлийн дундач өсөлтөөр дэлхийд тэргүүн байр эзлэх болсон юм. 1965 онд Япон экспортын хэмжээгээрээ томоохон улс гүрнүүдийн дотор тавдугаар байр эзэлдэг байсан бол 1985 онд гуравдугаар байранд, Өмнөд Солонгос далан наймдугаар байрнаас арван дөрөвдүгээр байранд үсрэнгүй дэвшин гарч иржээ. Импортын өсөлтийн хувьд Япон зургадугаар байрнаас гуравдугаар байранд, Өмнөд Солонгос тавин тавдугаар байрнаас арван гуравдугаар байранд хүрч иржээ.⁴ Японы экспорт, импортын хэмжээ одоо Ази, Номхон далайн бүс нутгийн экспортын 60-аас дээш хувь, импортын 55-аас дээш хувийг эзлэх болжээ.⁵ Ийнхүү Япон, Өмнөд Солонгосын гадаад худалдааны тэн хагасаас дээшхи

хувь нь Ази, Номхон далайн бүс нутаг руу чиглэх болсон нь тус бүс нутгийн эдийн засгийн хөгжилд зохих нөлөө үзүүлж байна.

Япон улс хөгжлийнхөө явцад худалдаа, шинжлэх ухаан техникийн гэсэн хоёр үе шатыг туулан өнгөрсний дараа мөнгөн зээллэгийн үе шатанд шилжсэнээр дэлхийн мөнгөн зээллэгийн гурван том төвийн нэг болжээ. Одоо Японы иен олон улсын зах зээл дээр АНУ-ын долларын дараа II байранд орж байна. 1987 онд Өмнөд Солонгосын нэг хүнд ноогдох нийгмийн нийт бүтээгдэхүүн 2813 долларт хүрснээр Зүүн хойт Азийн бүс нутагт тэргүүлэх байранд гарч иржээ. Япон, Өмнөд Солонгосын сүүлийн 20-нод жилийн эрчимтэй хөгжил нь Ази, Номхон далайн бүс нутгийн цаашдын хөгжлийг тодорхойлох хандлагатай болдоо. Энэхүү хөгжлийн цөм нь экспортод чиглэж, олон улсын хөдөлмөрийн хуваарь, эдийн засгийн бүсчлэлийг бүрэн дүүрэн ашигласанд оршиж байна. Техник, технологийг боловсронгуй болгон, гадаад худалдааг гол хөшүүргээ болгож «Экспорт ба хөрөнгө оруулалтын эргэлтэт систем»-ээр эдийн засгийг хөгжүүлжээ. Эдийн засгийн эргэлтэт систем гэдэг нь техник, технологийн, хөрөнгийн, үйлдвэрлэлийн гэсэн гурван том эргэлттэй юм. Энэ нь Япон, Өмнөд Солонгосын эдийн засгийн хүчин чадавхийг дээшлүүлж, их амжилтанд хүргэжээ. Хөгжлийн энэхүү загвар нь одоо Ази, Номхон далайн бүсийн олон улсын хөгжлийн туршлагаар нотлогдох болжээ. Дэлхийн эдийн засгийг интеграцчлах үйл явцаас үзэхэд бүс нутгийн шинжтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх нь зүй тогтолт үзэгдэл болж, тухайн бүс нутгийн эдийн засгийн хүрээг улам ашигтай нөхцөл байдалд хөгжүүлэх боломжийг олгож байна. Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн хөгжилд Зүүн хойт Азийн АНУ, Япон, Өмнөд Солонгос, Хятад, Орос зэрэг орон чухал нөлөөтэй юм. Орос, Хятад зэрэг улсуудад эдийн засгийн өөрчлөлт хийж, нээлттэй байх бодлого баримталж байгаа нь эдгээр оронд зах зээлийн харилцаа хөгжих нөхцөл бололцоог нээж байгаа юм.

Хятадын Ляонин, Жилин, Хэйлунжян гурван муж ба Өвөр монголын зүүн хэсэг Зүүн хойт Азид чухал үүрэгтэй болж байна. Хятадад 1978 оноос эдийн засгийн шинэчлэлт, нээлттэй байх бодлого баримталснаас хойш Зүүн хойт Азийн орнуудтай бүс нутгийн эдийн засаг, худалдааны харилцаагаа нэмэгдүүлсээр байна. 1984—1985 онд хятадын Зүүн хойт муж гадаадын улсуудтай аж ахуй, худалдааны 372 хэлэлцээр байгуулжээ.⁶ Хятадын зүүн хойт муж нь нийт хятадын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг ба орчин үеийн аж үйлдвэр хамгийн эрт хөгжсөн бүс нутгийн нэг юм. 1985 оны байдлаар хятадын зүүн хойт мужийн нийгмийн нийт бүтээгдэхүүн 2237,9 сая юаньд хүрсэн нь нийт хятадын нийгмийн нийт бүтээгдэхүүний 13,7 хувийг эзэлж байв. Хятадын энэхүү зүүн хойт муж нь нийт хятадын хөнгөн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 14, хүнд аж үйлдвэрийн 20, өнгөт металлургийн 20, алт, цагаан мөнгөний 40, үр тарианы 10, төмөр замын ачаа эргэлтийн 40, мөнгөн орлогын 13, шинжлэх ухаан техникийн ажилтны 14,5 хувийг тус тус эзэлж байна.⁷

Сүүлийн жилүүдэд Хятадын зүүн хойт муж эрчимтэй хөгжиж байгаа ба 1953—1988 онд дундчаар нийгмийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 8,8, аж үйлдвэрлэлийн нийт хэмжээ 11,7, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нийт хэмжээ 3,8 хувь тус тус өссөн байна. Экспорт, импортын хэмжээ 1988 онд 1950 оныхоос 90 дахин нэмэгдсэн ба 1988 онд 1028 сая долларт хүрсэн нь 1978 оны үеийн 206 сая доллартай харьцуулахад 4 дахин өсчээ.⁸ Хятад улс зүүн хойт мужаа хөгжүүлэх хэтийн төлөвлөгөөгөө арван тав, хорин таван жилээр төлөвлөн⁹ хэрэг-

жүүлж байгаа нь хамтын ажиллагааных нь хэлбэр хүрээг улам гөгтгөн баяжуулж байна.

Зах зээлийн эдийн засагт шилжиж буй Монгол улс улс төр, эди засаг, зах зээлийн шинэ шинэ түнштэй болж гадаад харилцааных орон зайг өргөтгөн тэлж байна. Гадаад харилцааны олон тулгуур бодлогыг тууштай хэрэгжүүлж дэлхийн хамтын нийгэмлэг, олон улсын эдийн засгийн харилцаанд нэгдэн интеграцчлагдах явдал чух болж байна. Иймээс манай улсаас бүс нутгийн интеграцид идэвхт оролцох арга замыг сүвэгчилж өөрийн байр сууриа олж бэхжүүл нь хэзээ хэзээнээс илүү ач холбогдолтой байна.

Энэ зорилгоор Ази, Номхон далайн бүс нутгийн болон эн тэргүү Зүүн хойт Азийн орнуудын хооронд өрнөж буй хөдөлмөрийн хуваарь хамтын ажиллагаанд үр бүтээлтэй оролцож, тус бүс нутагт гарч ба гаа нааштай хандлага, хоёр талын болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд идэвхи санаачлагатай ажиллах явдал шаардлагатай болж байна. Зүүн хойт Азийн бүс нутгийн аюулгүй байдал, хамтын ажиллагааны байнгын механизм тогтоох нь орон бүрийн эрх ашигт бүрэн нийцэж буй өнөө үед манай эрдэмтэд, мэрэгжилт нүүдийн идэвхтэй санаачлагаар жил бүр тус бүс нутгийн хүрээнд олон талын хамтын ажиллагааны асуудлаар эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах зэргээр яриа, хэлэлцээний байнгын механизм бий болон тогтмолжиж байгаа нь зохих үр дүнгээ өгч байна.

Зүүн хойт Азийн орнуудын эдийн засгийн хөгжил харилцан адиггүй байгаа ч гэсэн бүс нутгийн эдийн засгийг интеграцчлах явдал Ази, Номхон далайн бүс нутгийн төдийгүй дэлхий нийтийн эдийн засаг, техникийн хамтын ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх нь дамжиггүй. Сүүлийн жилүүдэд энэ бүс нутгийн усан болон төмөр замын агаарын харилцаа эрс сайжирснаар улс хоорондын харилцаа оло салбарт өргөсөж ялангуяа худалдааг хөгжүүлэхэд цаг, зардал хэмнэ зэргээр үр ашгаа үзүүлж байна.

Энэ бүс нутгийн хөгжлийн үйл явцад саад бэрхшээл, ярвигта асуудал гарч байгаа ч улс орон бүрийн идэвхтэй санаачлага, хүч зүтгэлээр хөгжлөө эрчимжүүлж, шинэ шинэ туршлага хуримтлуулва олон улсын эдийн засгийн харилцаанд илүү амжилт олох бололцоо хүч нөөц бүрэн байна. Иймээс ч эрдэмтдийн тооцоолж байгаагаа Зүүн хойт Азийн бүс нутаг нь XXI зуунд дэлхийн эдийн засгийн хөгжлийн гол хөдөлгөгч хүчин болох ба манай улс энэ бүс нутгийн орнуудтай хамтын ажиллагаагаа хөгжүүлснээр зах зээлийн харилцааны хөгжилдөө ихээхэн амжилт олж болох нь тодорхой байна. Манай Монгол улс төрийн тусгаар тогтнолоо цааш бэхжүүлж, эдийн засгийн аюулгүй байдлаа хамгаалах, эх нутгийнхаа байгалийн унаган төрхөө алдахгүй байх, ард түмний аж амьдралын түвшинг бууруулахгүй байх тулгын гурван чулуун дээрээ суурилан энэ хамтын ажиллагаанд оролцох нь мэдээж бөгөөд манай улсын эдийн засгийн амжилтыг хэмжих хэмжүүр нь энэ гурван тулгуур мөн. Бусад орны барааны зах болов бодитой аюулаас болгоомжлох ёстой. Хөгжлийн эерэг, сөрөг талын аль алины нь онц анхаарууштай байна. Дэлхийн ба бүс нутгийн зах зээлийн нөхцөлд өрсөлдөн хөгжих чадавхи бүхий эдийн засгийг бүх цогцолбор дэд бүтэцтэй нь буй болгох нь туйлын нарийн төвөгтэй асуудал юм. Үүнийг нийт нийгмийн хэмжээнд нийгэм байгалийн ухааны олон мэрэгжилтний хамтын оюунаар шийдвэрлэхээс өөр аргагүй нь мэдээж.

1. «Экономист» сэтгүүл, М., 1987. 12. 26,
2. Мөн тэнд. 1987. 11. 8

-
3. Ya tai yang jiu, Beijing (Ази Номхон далайн судлал, Бээжин, 1984, № 1, 5-р тал
 4. Su, Cao, qi dui wai jing ji guang si., Jilin., Зөвлөлт, Өмнөд Солонгос, Японы гадаад эдийн засгийн харилцаа, Жилин, 1988, 351-р тал.
 5. Wai guo wen ti yang jiu Jilin., (Гадаад орнуудын асуудлын судалгаа), 1990, № 2, e—2.
 6. Мөн тэнд.
 7. Di li yang jiu, Beijing., (Газар зүйн судлал), Бээжин, 1989, № 12, e—73.
 8. Wai guo wen ti yang jiu, Jilin., (Гадаад орнуудын асуудлын судалгаа), 1990. № 2, e—5.
 9. Guo ji wen ti yang jiu Beijing., (Олон улсын асуудлын судлал). 1985. № 4, 11-р тал